



АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Үндсэн хуулийн эрх зүйн маргаан¹)

ТИКТОК-ЫГ ХОРИГЛОХ НЬ ҮГ ХЭЛЭХ, ХЭВЛЭН НИЙТЛЭХ ЭРХИЙГ ЗӨРЧИХГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 24-656

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 01 сарын 17-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Маргаан бүхий хуулийг Үндсэн хууль зөрчөөгүй гэж шийдвэрлэсэн.

МАРГААНЫ ТУХАЙ ТОВЧ

Америкийн Нэгдсэн Улс (цаашид “АНУ” гэх) нь 2019 онд Гадаад дайсагнагч талын хяналттай аппликэйшнээс Америкчуудыг хамгаалах тухай хууль (англ. Protecting Americans from Foreign Adversary Controlled Applications Act)-ийг баталсан. Тус хуульд заасны дагуу гадаад дайсагнагч этгээдийн хяналттай аппикэйшныг АНУ-д түгээх, хадгалах болон шинэчлэх зэрэг тодорхой үйлчилгээг аливаа хуулийн этгээд үзүүлэх нь хууль бус юм. Энэ төрлийн аппликэйшнүүдэд “ByteDance Ltd”², “TikTok” (англ. TikTok)-ийн шууд болон шууд бус удирдлагад байдаг аливаа аппликэйшн хамаарах³ талаар хуульд нэрлэн зохицуулсан.

Үүнтэй холбоотойгоор ByteDance Ltd болон TikTok Inc, ТикТок-ын хэрэглэгч, контент бүтээгчид тус хуулийн биелэлтийг түр түдгэлзүүлэх, Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлт⁴-ийг зөрчиж байгаа болохыг шүүхээр тогтоолгох шаардлага бүхий гомдлыг АНУ-ын Колумбийн тойргийн давж заалдах шатны шүүх (англ. United States Court of Appeals for the District of Columbia Circuit (цаашид “Тойргийн шүүх” гэх))-д гаргасан байна.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Тойргийн шүүхийн шийдвэр: Тойргийн шүүх гомдол гаргагч нарын гомдлын шаардлагыг нэгтгэн хэлэлцэж 2024 оны 12 сарын 06-ны өдрийн шийдвэрээр

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://www.supremecourt.gov/opinions/24pdf/604us1r07_k536.pdf

² “ByteDance Ltd нь TikTok Inc -ийн толгой компани бөгөөд Хятад Улсад үйл ажиллагаа явуулдаг хувийн өмчийн компани юм” TikTok Inc. v. Garland, 604 U.S. 63 (Preliminary Print. 2025).

³ Protecting Americans from Foreign Adversary Controlled Applications Act, art. 2(g)(3)(A).

⁴ First Amendment to the U.S. Constitution “Конгресс (Congress) нь ... үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг ... хязгаарлах ёсгүй”



маргаан бүхий хуулийг Үндсэн хуульд нийцэж байна гэж үзэн гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.⁵

Холбооны Дээд шүүхийн шийдвэр, шийдвэрийн үндэслэл: Холбооны Дээд шүүх нь дараах үндэслэлээр маргаан бүхий хууль нь Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлтийг зөрчөөгүй гэж шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. Үндсэн хуулийн **Нэгдүгээр нэмэлтийн үндсэн зарчим нь хүн бүр өөрийн үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, хүлээн авах, дагаж мөрдөх эсэхийг өөрөө шийдвэрлэх** явдал юм. Төрийн үйл ажиллагаа үг хэлэх эрх чөлөөг мэдээллийн агуулгаар хязгаарлаж буй тохиолдолд энэ нь үндсэн эрхийн зөрчил болно. Энэ төрлийн хууль нь “агуулгыг хязгаарласан хууль” (англ. content-based laws) болох бөгөөд **төрөөс зөвхөн чухал ашиг сонирхлыг хангах зорилгоор хязгаарлалт тогтоох ба тухайн хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд зайлшгүй, тохирсон байх шаардлагатай**. Харин үг хэлэх эрх чөлөөг агуулгаас бусад хэлбэрээр хязгаарлаж буй хуулийг “агуулгад үл хамаарах хэсгийг хязгаарласан хууль” (англ. content- neutral laws) гэх бөгөөд энэ төрлийн хууль нь дунд түвшний шалгуур (англ. intermediate scrutiny)-аар хянагддаг.⁶ **Маргаан бүхий хуулиар ТикТок платформ (англ. platform)-ыг АНУ-д үргэлжлүүлэн үйл ажиллагаагаа явуулахыг хориглосон. Хууль нь үг хэлэх эрх чөлөөг агуулгын хувьд хязгаарлахтай холбоогүй тул маргаан бүхий хууль нь агуулгад үл хамаарах хэсгийг хязгаарласан хууль болно. Мөн тус хуулиар төрийн чухал ашиг сонирхол (АНУ-ын ТикТок хэрэглэгч иргэдийн хувийн мэдээллийг хамгаалах, үндэсний аюулгүй байдал)-ыг хангах зорилготой бөгөөд хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд зайлшгүй шаардлагатай хэмжээнээс хэтрээгүй** байна.
2. Гомдол гаргагчид ТикТок-той адил өгөгдөл цуглуулдаг өөр бусад аппликэйшнүүдыг зохицуулалтаас чөлөөлсөн нь ялгаварлан гадуурхсан үйлдэл гэж маргасан. Гэвч гадаад дайсагнагч этгээд энэхүү платформыг хянах замаар АНУ-ын 170 сая хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах боломжтой тул ТикТок-ыг онцгойлон зохицуулах нь үндэслэлтэй байна. Мөн **ByteDance Ltd-ийн эрх Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлтээр хамгаалагдахгүй**⁷ юм.

Дээрх үндэслэлээр Холбооны Дээд шүүх маргаан бүхий хуулийг гомдол гаргагчдын Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлтээр хамгаалагдсан эрхийг зөрчөөгүй гэж үзэн Тойргийн шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

---o0o---

⁵ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <chrome-extension://efaidnbmnnnnibpcajpcglclefindmkaj/https://media.cadc.uscourts.gov/opinions/docs/2024/12/24-1113-2088317.pdf>

⁶ TikTok Inc. v. Garland, 604 U.S. 70 (Preliminary Print. 2025).

⁷ “Гадаад улсад үйл ажиллагаа явуулж буй гадаад улсын хуулийн этгээд АНУ-ын Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлтээр хамгаалагдахгүй” as cited in TikTok Inc. v. Garland, 604 U.S. 69 (Preliminary Print. 2025).